

ТУСГАЙ ТЕХНОЛОГИ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, НӨХӨН ОЛГОДОГ ПРОТЕЗИЙН (ХИЙМЭЛ ЭРХТЭН) ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ДОТООДЫН ЗӨВЛӨХ ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ЗАР

Төслийн дугаар: 48076-002

Төслийн нэр: L3605/G9191-МОН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД:

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын Засгийн газар (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх замаар нийгмийн болон эрхийн асуудлыг нь шийдвэрлэхэд Монгол улсын Засгийн Газарт дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Төслийн эцсийн зорилго нь ХБИ-ний бие даах чадварыг дээшлүүлж, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Төсөл нь 5 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Илүү мэдээллийг <https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>-аас авна уу.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь тусгай технологи, тусгай хэрэгсэл, нөхөн олгодог протезийн хүртээмжийг сайжруулах зорилгоор нэг гадаадын болон нэг дотоодын зөвлөлтэй хамтран ажиллана. Зөвлөхүүдийг “Азийн Хөгжлийн Банк ба түүний зээлдэгч зөвлөхийг ашиглах журам”-д (2013 он) заасны дагуу ХНХЯ шалгаруулна.

Зөвлөх үйлчилгээ дараах ерөнхий зорилтуудаас бүрдэнэ. Үүнд:

Зорилт 1. Тусгай технологи, тусгай хэрэгсэл, нөхөн олгодог протезийн хүртээмжийг сайжруулах тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх; Одоогийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд ХБИ-дэд хамгийн шаардлагатай байгаа тусгай хэрэгсэлд хамрагдах/нөхөн олгох боломжтой туслах хэрэгслийн жагсаалтыг үнэлэх;

Зорилт 2. ХБИХЕГ-ын харьяа протез, ортопедийн үйлдвэр, мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль, 6 аймаг дахь Хөгжлийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийг сайжруулах зөвлөмж боловсруулах; Худалдан авах тоног төхөөрөмж, туслах хэрэгслүүдийн жагсаалтыг техникийн үзүүлэлтүүдийн хамт тодорхойлох;

Зөвлөх үйлчилгээ нь дараах хүрээний ажлуудыг хийх боловч уг ажлаар хязгаарлагдахгүй болно.

Дотоод зөвлөх нь гадаад зөвлөхийн хийх дараах ажлуудад дэмжлэг үзүүлж ажиллана.

- Тусгай технологи, тусгай хэрэгсэл, нөхөн олгодог протезийн хэрэгцээг тооцоолоход хэрэглэгдэж болох бүх мэдээллийг эрүүл мэндийн эрсдэлийн үзүүлэлттэй уялдуулан үнэлэх; тусгай технологи, тусгай хэрэгсэл, нөхөн олгодог протезийн одоо байгаа эрэлт, нийлүүлэлт болон худалдан авалтын системийг үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн Монгол улсын тусгай хэрэгслийн үйлчилгээг сайжруулах, дараагийн алхмыг тодорхойлоход ХНХЯ (ХБХХЕГ), ЭМЯ, ХБИБ зэрэг оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх гадаад зөвлөхийн ажилд хувь нэмэр оруулна, холбогдох уулзалт, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна;
- Одоогийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд ХБИ-дийн хэрэгцээнд тохируулан олгодог/нөхөн олгодог тусгай технологи, хэрэгслийн нэн шаардлагатай тусгай технологи, хэрэгслийн жагсаалтыг үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ; түүнчлэн шаардлагатай тусгай технологийн худалдан авалтыг ил тод, эрх тэгш тогтолцоог, хэрэгжихүйц байдлыг харгалзан боловсруулахад дэмжлэг үзүүлэх; Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, ICF, болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн нөхөн олгох тусгай хэрэгсэл ба төхөөрөмжийн жагсаалтыг тодорхойлох үүрэг хариуцлагын талаарх журамд оруулах өөрчлөлтийн саналыг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллана;
- Аль ортопед, тусгай хэрэгсэл болон хиймэл эрхтнийг /протез/ Монгол улсад бодитойгоор үйлдвэрлэж чадах эсэхийг судалж, зөвлөмж боловсруулахад гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлнэ;
- Тусгай технологийг үйлдвэрлэх болон худалдан авалтын доод стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ; Үндэсний хэмжээнд тусгай хэрэгслийг олгодог тогтолцооны хүрээнд сайн хэрэгжихүйц тусгай хэрэгслийн доод стандартыг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны зааврыг боловсруулахад гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлнэ;
- Төслийн 6 аймгийн Хөгжлийн төвүүдэд хөдөлгөөн болон ахуй засал, ICF-ийн үнэлгээг хийхэд ашиглах тусгай технологи, хэрэгслийн худалдан авалтын багцыг бэлтгэхэд гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлнэ; Ямар тусгай технологийг Хөгжлийн төвүүд дээр засварлах боломжтойг тодорхойлоход гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлнэ;
- Улсаас олгодог тусгай хэрэгсэл болон тоног төхөөрөмжийн жагсаалтыг тодорхойлдог олон улсын шилдэг туршлагын талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилготой туршлага судлах аяллыг Засгийн Газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдэд зориулан төлөвлөх, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхэд гадаад зөвлөхөд тусална;
- ХБИХЕГ-ын харьяа протез, ортопедийн үйлдвэрийн өнөөгийн хүчин чадалд үнэлгээ хийж, тоног төхөөрөмжийг сайжруулах зөвлөмж боловсруулах; Худалдан авах тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг техникийн үзүүлэлтүүдийн хамт тодорхойлох;
- ХБИХЕГ-ын харьяа мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийг сайжруулах зөвлөмж боловсруулах; Худалдан авах

тоног төхөөрөмж, туслах хэрэгслүүдийн жагсаалтыг техникийн үзүүлэлтүүдийн хамт тодорхойлох гадаад зөвлөхийн ажилд дэмжлэг үзүүлнэ;

D. ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол: Эрүүл мэнд, ахуй болон хөдөлгөөн засал, хэл засал, эсвэл биоинжинерчлэл, ортопед технологи эсвэл дүйцэхүйц чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага: Доод тал нь 10 жил сэргээн засах, нөхөн сэргээх болон/эсвэл ортопед технологи, биоинжинерчлэлийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай; хөдөлгөөний, харааны, сонсголын, харилцаа холбооны, танин мэдэхүйн болон орчны бүх л хүрээний боломжит туслах хэрэгсэл, технологийн талаар сайн мэдлэгтэй; ICF-ийг ХБИ-д болон ХБХ-д зориулан туслах хэрэгслүүдийг сонгох болон ажиллагааг нь шалгаж үнэлэхэд ашиглаж байсан туршлагатай; ХБИБ-ууд болон Засгийн газартай хамтран туслах хэрэгслүүдийн үндэсний бодлого, механизмыг тодорхойлж байсан туршлагатай бол давуу тал болно;

Хэлний мэдлэг: Англи хэлний ярианы болон бичгийн өндөр түвшний мэдлэгтэй байх;

E. ХЯНАЛТ, ТАЙЛАН:

- Зөвлөх нь ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар /ХАХГ/-ын дарга болон Төслийн зохицуулагчид ажлаа тайлагнана. Ажлын явцын тайланг ажлын хэсгийн хуралд танилцуулна /шаардлагатай бол бусад уулзалтаар/.
- Зөвлөхийг ажлаа эхлүүлснээс хойш долоо хоногийн дотор Захиалагч нь ажлын төлөвлөгөөг батлах бөгөөд энэ төлөвлөгөөг зөвлөх үйлчилгээний туршид төлөвлөсөн үр дүнгийн явцыг дүгнэхэд ашиглана.
- Дотоод зөвлөх нь ХНХЯ-нд зөвлөлдөх уулзалт хийх, оролцогч талуудтай зөвшилцөхөд гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлж ажиллана. Зөвлөх нь холбогдох байгууллага, агентлагуудын гаргасан санал, зөвлөмжийг үндэслэн баримт бичгийг засах, эцэслэх үүрэгтэй. Тайланг шаардлагатай бол ажлын хэсгийн эсвэл бусад оролцогч талуудын хуралдаанд танилцуулна.
- Зөвлөх нь гадаадын зөвлөхтэй баг болон хамтран ажиллана. Зөвлөх нь зөвлөх ажилтай холбоотой зохицуулалт болон зохион байгуулалтын асуудлаар дотоодын зөвлөх болон төслийн захирлын томилсон холбогдох мэргэжилтнүүдтэй өдөр тутам хамтран ажиллана.
- Бүх тайлангууд хоёр хэл дээр бэлтгэгдэнэ (Монгол, Англи).
- ХНХЯ, Эрүүл мэндийн яам нь зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах бичиг баримттай танилцах боломжоор хангана. Төсөл хэрэгжүүлэх нэгж оффисоор хангана.

Ажлын даалгавар болон бусад холбогдох мэдээллийг доорх цахим хаягаас авах боломжтой <http://csrn.adb.org>. Оролцох сонирхол бүхий зөвлөхүүд өөрсдийн CV-ийг Англи хэл дээр АХБ-ны Зөвлөх менежментийн систем болох cms.adb.org хаягаар орж онлайнаар, эсхүл 1 эх хувь цаасан материалыг 2020 оны 3-р сарын 18-ны өдрийн 16:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар ажлын цагаар 9:00-17:00 цагийн хооронд авах боломжтой.

Материал хүлээн авах хаяг

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн нэгж, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Макс цамхаг, 7 дугаар даврах 703 тоот
Холбогдох дугаар: 976-7733-5577
Цахим хаяг: bolortuya@pwdp.mn**